Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх ажлын хэсгийн хурлын тэмдэглэл

Ажлын хэсгийн хурлыг Төрийн ордны зүүн талын 4 давхар "Цэцийн заал"-д 2006 оны 4 дүгээр сарын 14-ны 10.00 цагт хийлээ. Хурлын ирцийг хавсаргав. Хуралдаан эхлэхийн өмнө ажлын хэсгийг баталсан Ерөнхий сайдын захирамж, Олборлох салбарын ил тод байдлын санаачлага Сурвалж бичиг номыг ажлын хэсгийн гишүүдэд гарын авлага болгон өглөө.

Хурлыг Ажлын хэсгийн ахлагч, Ерөнхий сайдын эдийн засгийн зөвлөх Д.Батбаяр нээж дэлгэрэнгүй үг хэлэв. Нээж хэлсэн үгийг хавсаргав. Тэрээр хурлыг удирдав.

Дэлхийн банкны Монгол дахь төлөөлөгчийн газрын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын асуудал хариуцсан зөвлөх Г.Цогтсайхан үг хэлэв. Г.Цогтсайхан хэлэхдээ Дэлхийн банк, Олон улсын валютын сан дэлхийн олон оронд тусламж үзүүлж ирсэн, гэтэл уул уурхайн хөгжлийг судалж үзээд зарим оронд уул уурхайгаас орох орлого тодорхой бус, тэнд авилгал гарч байгааг, уул уурхайн үйлдвэрлэлийн орлого нь хүн ардад хүрэхгүй байгааг ажигласан. Нигер зэрэг зарим оронд уул уурхайг корпорациуд олборлодог, Засгийн газартай гэрээ байгуулдаг. Тэнд чухам юу болж байгаа нь мэдэгддэггүй, авилгал, хээл хахуул газар авсан байна. Энэ байдлаас гарах зорилгоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачлагыг төрийн бус байгууллагаас дэвшүүлж улмаар Их Британи, Умард Ирландын Вант Улсын Ерөнхий сайд Тони Бейлэр санаачилж одоо 22 орон дэмжээд байгаагийн дотор манай улс бүртгэгдсэн.

Манай улс өнгөрсөн оноос хэрэгжүүлэх гэж Дэлхийн банк зэрэг газарт хүсэлт тавьсан. Дэмжсэн, жижиг групп явуулж Киргизэд туршлага судалсан. Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод, Засгийн газар дэмжсэн, Үндэсний зөвлөл, ажлын хэсэг байгуулсан. Засгийн газар солигдож ажил удааширсан. Бид уг нь энэ жил анхны тайлан гаргах байсан. Чадвал тайлан гаргах зорилготой. Дэлхийн банкны энэ асуудлыг хариуцсан ажилтан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболдтой уулзсан, ажлын албанд 2 хүн ажиллуулна, түүнийг санхүүжүүлнэ. Соросын сан энэ санаачлагыг дэмждэг, Нээлттэй нийгэм форумын Эрдэнэжаргал энд сууж байна. Сэтгүүл орчуулж гаргасан.

Энэ санаачлагын мөн чанар нь улсын төсөвт орж байгаа орлогыг ил тод болгоё, аудит хийлгэе, сайн засаглалыг хөгжүүлэх явдал юм.

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа-ажлын хэсгийн төлөвлөгөөний төсөл, ажлын хэсгийн ажиллах чиглэлийн талаар товч танилцуулав.

Г.Цогтсайхан-Ажлын төлөвлөгөөг хэн батлах вэ, ажлын хэсэг өөрөө батлах, Үндэсний зөвлөлөөр батлуулах хувилбар байж болно. Хамгийн чухал асуудал бол аж ахуйн нэгжийг санаачлагад хамруулаад тайлан гаргах, тайланг ямар маягтаар гаргах вэ гэдгийг бид хамгийн түрүүнд шийдвэрлэх ёстой.

Үндэсний татварын ерөнхий газрын дарга Л.Зориг-Манай алба энэ санаачлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй, татвар төлсөн бүртгэл манайд бий, 10 жилээр ч гаргаж болно. Харин аж ахуйн нэгжийн тухайн аймаг, сумандаа өгсөн тусламж, барьсан байгууламж зэргийн мэдээлэл байхгүй. Төрийн байгууллагууд хэрэгжүүлнэ. Төлөвлөгөөний төслөө сайн танилцаж дараагийн 7 хоногт батлая. Аж ахуйн нэгж, байгууллагууд нэгдэж орох уу, санаачлагад нэгдэн орох тухай хууль тогтоомжид заалт байхгүй, бид элдэв хардлага сэрдлэгээс хол байх ёстой, наад зах нь 100-гаад аж ахуйн нэгжийн төлөөлөгчдийг хамруулан уулзаж ярилцая. Төлөвлөгөөний төслөө дараагийн 7 хоногт өгөе.

Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал Эрдэнэжаргал-Сайн дурын санаачлага-энэ нь улс орон нэгдэх нь сайн дурын зүйл. Санаачлагад Засгийн газар нэгдсэн бол санаачлагыг хэрэгжүүлэх нь албаны ёсны ажил болж байгаа. Зарим оронд туршилтын гээд зарим аж ахуйн нэгжид туршиж байгаа. Ямар үзүүлэлтээр тайлан гаргах, хэн аудит хийх, төлөвлөгөөнд төрийн бус байгууллагын эвсэл байгуулах гэж оруулах уу, яах вэ. Энэ онд тайлан гаргах зорилт тавьж туршилтын компанийн хүрээнд гаргая. Ажлын хэсэг яаж ажиллах вэ гэвэл ажлын төлөвлөгөөнд хариуцах ээн гэж бичигдсэн хүмүүс санал бэлтгэнэ, төлөвлөгөөг урьдчилсан байдлаар баталж, дараа нь нэмэлт оруулж болно. Манай форум Дэлхийн банкны 30 мянган ам.доллар, Нээлттэй нийгэм форумын 30 мянган ам.долларын хөрөнгөөр иргэний нийгмийн байгууллагыг чадавхжуулах арга хэмжээ авна. Ажлын хэсэг Засгийн газар, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага хамтарч ажиллах үлгэр жишээ болгож ажиллая.

Уул уурхайн асоциацийн ерөнхийлөгч До.Ганболд-Үндэсний зөвлөл, ажлын хэсэг 2 ямар харилцаатай байх вэ.

Г.Цогтсайхан-Ажлын хэсэг хэрэгжүүлэх үүрэгтэй, асуудлаа боловсруулна, Үндэсний зөвлөл удирдана, хяналт тавина, улс төрийн тевшний шийдвэр гаргана. Энэ хоёрын харилцааг уян болгох хэрэгсэл болгож Үндэсний зөвлөлийн дарга Ерөнхий сайд бол ажлын хэсгийн ахлагч Ерөнхий сайдын ахлах зөвлөх юм.

Д.Батбаяр-Засгийн газар олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ гэдгээ албан ёсоор илэрхийлсэн учир дэмжиж ажиллана. Үндэсний зөвлөл үндэсний хэмжээний асуудлаа шийдвэрлэнэ.

Нүүрс ассоциацийн тэргүүн Даваацэдэв-Ажлын алба, ажлын хэсгийн хооронд ямар ялгаа байна, ажлын хэсэг ямар хэлбэрээр ажиллах журам чухал байна.

Г.Цогтсайхан-Ажлын алба бол Ажлын хэсгийн ахлах, ажлын хэсгийн нарийн бичгийн даргын дэргэд ажиллана.

Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Ц.Ганхуяг-Төлөвлөгөөний төслийн 4-т байгаа асуудлаар аж ахуйн нэгжүүдээс санал авах, энэ талаар бэлтгэл ажилдаа юу хийхээ бодох хэрэгтэй.

Д.Батбаяр-Ажлын хэсэгт орж байгаа аж ахуйн төлөөлөл бүх аж ахуйн нэгжийг төлөөлж чадах уу гэсэн асуулт гарч байна, бүрэлдэхүүнээ эргэж харж болно.

Айвенхоу майнз компаний дэд ерөнхийлөгч Мөнхбат-Өнгөрсөн оны 12 дугаар сард болсон энэ чиглэлээр манайд зохион байгуулсан олон улсын бага хуралд манай компани дээд удирдлагын түвшинд өргөн хүрээтэй оролцсон, энэ санаачлагыг анхнаас нь дэмжсэн. Орлогыг хэрхэн хуваарилах нь ил тод байх ёстой. Манай компани хайгуул хийж байгаа, баяжуулах үйлдвэр байгуулах бэлтгэл хангаж байна. Олон нийт татвар бага өгч байна гэдэг. Хайгуул хийж байгаа учир татвар бага байгаа, иймд хайгуул хийж байгаа ч, үйлдвэрлэл явуулж байгаа ч энэ санаачлагад хамаарах хэрэгтэй. Бид санхүүгийн төлөвлөгөө зохиосон, олон улсын шинжээчид танай санхүүгийн төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар ч, олон нийт ч ойлгох чадавхи байна уу гэж асууж байна. Ажлын хэсэг бол түр ажиллах, харин зөвлөл бол байнгын ажиллана гэсэн ойлголттой байна. Төлөвлөгөөгөө батлаад ажиллая.

Төрийн өмчийн хорооны Тамгын газрын дарга О.Батмөнх-Захирамжаас харахад ажлын хэсэг бол хэрэгжүүлэх үүрэгтэй юм байна. Төлөвлөгөөг батлаад зарим зүйлийг тодотгоод явъя. Ажлын хэсэг гэдгийг санаачлагын зөвлөл гэе. Бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл цөөн байна. Уул уурхайн ассоциаци, Нүүрсний ассоциацийн төлөөлөл нь үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаална. Иймд өргөтгөх хэрэгтэй. Санаачлагад аж ахуйн нэгжийг албадан оруулах нь зүйтэй. Иймд хууль тогтоомжид зохих өөрчлөлт оруулая. Манай хуулиар бол нээлттэй компани санхүүгийн тайлангаа сонинд нийтэлж байх ёстой. Гэтэл манайд хэрэгждэггүй. Иймд санхүүгийн тайланг нийтэлж байх саналтай гэв.

"Онги голынхон" хөдөлгөөний тэргүүн Ц.Мөнхбаяр-Санаачлагад нэгдэх нь сайн дурын асуудал. Мэдээллийн үнэн зөв, эсэхэд хэн ч итгэхээ больсон нь үнэн зүйл. Мэдээллийн ил тод байдлыг хангах нь зөв. Айвенхоугийн үйл ажиллагаанд хэн ч хяналт тавьж чадахгүй байгаа. Төрийн бус байгууллагын төлөөлөл тэнцвэртэй биш байна. Төрийн бус байгууллага эвсэл болж байгаа, тухайлбал шинээр бий болсон хөдөлгөөнүүд эвсэл болон ажиллаж байна. Санаачлагад аж

ахуйн нэгжийг хамруулахдаа орлогын босго тогтоож болохгүй. Жижиг компаниуд байгаль хамгийн их сүйтгэж, тэд орлогоо их хэмжээгээр нууж байгааг хэлэх байна.

Д.Батбаяр-Харилцан зөвшилцөж ажиллана. Том компаниуд бусад компаниа төлөөлж чадах уу.

Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Батжаргал-Төлөвлөгөөг авч үзэхэд олон оролцогч байна. Татвар, орлогын асуудлыг Засгийн газрын түвшинд Үндэсний татварын ерөнхий газар, Улсын мэргэжлийн хяналтын газар хянаж байгаа.

Энэ өрөөнд болох дараагийн хурлын цаг болсон тул хурлаа дуусгав.

Д.Батбаяр-Ажлын төлөвлөгөөнд өгөх саналаа дараагийн нэг дэх өдөр ирүүлнэ үү. Бид үзэж төсөлд тусгая гэв.

Хурал 1 цаг 25 минут үргэлжлэв.

Тэмдэглэлтэй танилцсан:

Ажлын хэсгийн ахлагч: **Д.БАТБАЯР**

Тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга

Э.СУМЪЯА